

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХУРЛЫН ХУРААНГУЙ

Улаанбаатар

2025 он

Оюутны эрдэм шинжилгээний хурал

ЭМХЭТГЭЛИЙГ ЭРХЭЛСЭН:

ЭШИГ-ын мэргэжилтэн, доктор, Ж.Дуламсүрэн

МУБИС, Эрдэм шинжилгээ, инновацын албанаас эрхлэв.

Улаанбаатар, 2025 он

Гарчиг

Хиймэл дагуулын мэдээг ашиглан уур амьсгалын өөрчлөлтийг судлах арга зүй (Сүхбаатар аймгийн Халзан сумын жишээн дээр) <i>Батбилэг Сэдэд</i>	2
Уураг дахь сонгодог β -эргэлт төрлийн хоёрдогч бүтэц <i>Төмөртулга Пүрэвдолгор</i>	3
Хувь хүний суралцах хэв маягт тохирсон хиймэл оюунд суурилсан ухаалаг системийн нэгэн хувилбар <i>Хүрлээ Хүслэн, Ганболд Дагвадорж, Батнасан Болормаа</i>	3
Тэгш хамруулан сургах боловсролд сургуулийн удирдлагын оролцоо (ЕБС-ийн жишээн дээр) <i>Даваадорж Номин</i>	4
“Хүргэдэд талбих” заншлын үүсэл, хувирал, үлдэц <i>Гэрэлтуяа Ундрах</i>	5
Монгол хэлний үйл үгийн утгын өргөслийг судлах нь (“Ор” үйл үгийн жишээн дээр) <i>Цэдэндамбаа Сувд-Эрдэнэ</i>	5
Гурван настай хүүхдийн математик энгийн төсөөлөл чадварыг гар утасны тоглоом ашиглан хөгжүүлэх нь <i>Анхбаяр Хонгорзул</i>	6
Үндэсний бичгээр уншиж ойлгох чадварын судалгаа (ЕБС-ийн X ангийн сурагчдын жишээн дээр) <i>Энхбаяр Аззаяа</i>	7
Сурагчдын бие даан суралцах чадварт метакогнитив суралцахуйн үзүүлж буй нөлөө <i>Галбадрах Сүнжидмаа</i>	8
МСБХ-ны цахим хуудсанд нийтлэгдсэн спортын гэрэл зурагт хийсэн ажиглалт <i>Батбаатар Чойжамц</i>	9
Лигийн тоглолтын тайлбарлагчдын ур чадварт хийсэн ажиглалт <i>Юмжин Наранцогт</i>	9
Сурагчдын суралцах хэв маягийн судалгаа <i>Мөнх-Эрдэнэ Нандин-Эрдэнэ</i>	9
Хүүхдийн зурсан зургаар дамжуулж гэр бүлийн харилцааг шинжих нь <i>Отгонбаяр Энхжин</i>	10

STEM хичээлийн төлөвлөлт, туршилтын үр дүнд хийсэн шинжилгээ <i>Лувсандэмбэрэл Ануужин</i>	11
Тавдугаар ангийн сурагчдын геометрийн агуулгын хүрээнд эзэмшсэн мэдлэг чадварыг үнэлэх арга зүй <i>Алтангэрэл Дарханцэцэг</i>	11
Дижитал технологийг үр дүнтэй ашиглаж буй өнөөгийн байдал (Бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын жишээн дээр) <i>О.Цэндсүрэн, А.Дуламсүрэн, Б.Нэргүй, О.Энхзул</i>	12
Монтессори сургалтын арга зүйг туршсан үр дүн <i>Сүрэнхорол Цэрэнбадам</i>	12
3-4 настай хүүхдийн хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх боломжийг судалсан нь <i>Болдбаатар Сарангэрэлмаа</i>	13
Залуучуудын худал мэдээлэлд итгэх нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлүүд <i>Баярмагнай Солонго, Булганчимэг Энхтөр</i>	13
Байгууллагын стрессийн түвшинг тодорхойлон, нөлөөлөгч хүчин зүйлд хамаарлын шинжилгээ хийсэн үр дүн <i>Цэрэнтүрэв Цээжаргал</i>	14

Хиймэл дагуулын мэдээг ашиглан уур амьсгалын өөрчлөлтийг судлах арга зүй
(Сүхбаатар аймгийн Халзан сумын жишээн дээр)

Батбилэг Сэдэд
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик,
Байгалийн ухааны сургууль, Газарзүйн тэнхим
Sededbatbileg2@gmail.com

Хураангуй. Сүүлийн хэдэн арван жилд уур амьсгалын өөрчлөлт дэлхий дахинд анхаарал татсан томоохон асуудлын нэг болсон бөгөөд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн олон салбарт шууд болон шууд бус нөлөө үзүүлж байна. Мөн хиймэл дагуулын мэдээлэл, зайнаас тандан судалгааны технологиуд хурдацтай хөгжиж, уур амьсгалын урт хугацааны өөрчлөлтийн томоохон зай, цаг хугацааны хэтийн төлөвтэй үнэлэх боломжийг бүрдүүлж байна. Ялангуяа Google Earth Engine (GEE) зэрэг үүлэн технологид суурилсан платформ нь хиймэл дагуулын өгөгдлийг боловсруулж, төрөл бүрийн шинжилгээ хийхэд үр ашигтай, цаг хугацаа хэмнэсэн хэрэглүүр болж байна. Иймд энэхүү судалгаагаар Сүхбаатар аймгийн Халзан сумын жишээн дээр хиймэл дагуулын мэдээллийг ашиглан уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэлтүүд болох ургамалжилтын нормчилсон индекс (NDVI), гадаргын температур, хур тунадасны өөрчлөлтийг 2000 оноос 2024 оны хооронд 6 дугаар сарын 01-нээс 8 дугаар сарын 31-ны хооронд дахь өдрүүдийн дундаж утгуудыг боловсруулж, уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны арга зүйг боловсруулах, үнэлэх боломжийг эрэлхийлсэн юм. Судалгааны хүрээнд NDVI, гадаргын температур, хур тунадасны 25 жилийн жил тус бүрийн дундаж утга болоод нийт дундаж утгуудыг хүснэгт, графикаар болон газарзүйн зураг дээр дүрсэлсэн юм. NDVI-ийн утга бага зэрэг өсөх хандлага ажиглаж байгаа бол гадаргын температур буурч, хур тунадас харьцангуй нэмэгдэж байгааг тус судалгаагаар тогтоосон. Дээр дундаж утгуудыг ашиглан NDVI болон хур тунадасны хоорондын хамаарлыг Пирсоны корреляцийн шинжилгээгээр тодорхойлоход $r \approx 0.12$ нэгж буюу сул эерэг хамаарал ажиглагдсан ба энэ нь хур тунадас нэмэгдэхэд ургамлын ургалт бага зэрэг сайжирч байгааг илтгэж байгаа ч статистикийн ач холбогдолгүй, хамаарал маш сул гэж үзэж болохоор байна. NDVI-ийн урт хугацааны хандлагыг Mann-Kendall тестээр үнэлэхэд $S=0.00371442$, $Z=-0.0233$, $P=0.9814$ гэсэн үр дүн гарсан бөгөөд энэ нь NDVI-ийн өөрчлөлт тодорхой чиглэлтэй биш буюу тодорхой шалтгаантайгаар нэмэгдсэн эсвэл буурсан биш ямар нэгэн хандлагагүй 0 түвшинд байгаа болохыг харуулж байна. Үүнийг батлахын тулд Sen's Slope шинжилгээ хийхэд NDVI нь жилд дунджаар 0.0037 нэгжээр өссөн гэсэн үзүүлэлт нь Mann-Kendall тестээ баталж байгаа бол хур тунадас нь 0.0296 мм-ээр нэмэгдсэн хандлагатай гарсан. Энэ нь NDVI-аас 8 дахин их байгаа нь корреляцийн дүн шинжилгээгээ баталж байгаа юм. Эдгээр утгууд нь нийт хугацааны туршид тодорхой хэмжээнд ургамлын болон хур тунадас нэмэгдсэн чиглэлтэй буюу эерэг утгатай боловч өсөлтийн хурдац харьцангуй бага бараг л 0 байгааг илтгэнэ. Түүнчлэн судалгааны үр дүнд үндэслэн орон зайн хувьд өөрчлөлтийн хандлагыг тусгасан газарзүйн зураг боловсруулсан бөгөөд энэ нь тухайн бүс нутагт уур амьсгал хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулан харах, орон нутгийн онцлогийг үнэлэх боломжийг бүрдүүлсэн. Иймд энэхүү судалгаагаар хиймэл дагуулын өгөгдөл болон үүлэн технологийн (Google Earth Engine) тооцоололд суурилсан платформыг ашиглан уур амьсгалын том хэмжээний орон зай, урт хугацааны хандлагыг тодорхойлох арга зүйн боломж, хязгаарлалыг харуулах, цаашдын судалгаанд арга зүйн талаас хэрэг болох ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Уур амьсгалын өөрчлөлт, хиймэл дагуулын мэдээ, Google Earth Engine, NDVI-ийн өөрчлөлтийн чиг хандлага, Mann-Kendall тест, Sen's Slope тест
Удирдсан: Ц.Бат-Эрдэнэ, МУБИС

“Уураг дахь сонгодог β -эргэлт төрлийн хоёрдогч бүтэц”

Төмөртулга Пүрэвдолгор
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик,
Байгалийн ухааны сургууль, Физикийн тэнхим
purevdolgor1123@gmail.com

Хураангуй. Одоогийн байдлаар 230 гаруй сая уургийн молекулыг бүрдүүлэх амин хүчлийн дараалал тодорхойлогдсон. Эдгээрээс 202,414 уургийн макро молекулын 3-хэмжээст кристалл бүтцийг рентген дифракцын аргаар тогтоосон. Энэ нь амин хүчлийн дараалал нь мэдэгдэж буй уургийн дөнгөж 0.09% байна. Иймд уургийн хоёрдогч бүтцийг тодорхойлж, үүргийг тайлбарлахад туршилтын аргууд (рентген туяаны дифракц, NMR, Электрон микроскоп гэх мэт)-ыг орлож чадахуйц компьютерын тооцооллын арга зүйг хөгжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаан, машин сургалтын аргууд ашиглан уургийн амин хүчлийн дарааллын мэдээллээс хоёрдогч бүтэц, түүний дотор β -эргэлт (beta-turn) зэрэг хоёрдогч бүтэц тодорхойлох судалгаанууд эрчимтэй хийгдэж байна. Иймд загварчлалын аргуудаар PDB зэрэг өгөгдлийн сангууд дахь бүтэцтэй харьцуулах болон тооцооллын аргуудыг хослуулан уургуудын өгөгдөлд үндэслэн уургийн 3-хэмжээст бүтцийг таамаглах боломжийг олгож байна. Сонгодог 9 төрлийн β -эргэлт бүтцийн үндсэн шинж чанарыг тодорхойлохыг зорьсон. PROMOTIF программ ашигласан. Судалгааны үр дүнд 4057 нь бета эргэлт илрүүлсэн бөгөөд үүний хамгийн их 34.7% хувийг I төрлийн бета эргэлт эзэлж байсан бол хамгийн бага хувийг VIa2 төрлийн бета эргэлт эзэлж байна. Өнцгийн утгууд бол өмнө нь тодорхойлсон классик утгуудтай ер нь бол ойролцоо утгатай гарсан. Хамгийн олон тохиолдсон буюу I төрлийн өнцгийн түгэлтийг тодорхойлоход утгууд нь тодорхой хэмжээгээр нормаль утгатай гарсан. IV төрлийн β -эргэлтийн ϕ , ψ өнцгийг шалгахад нормаль түгэлт хэдий гарч байгаа боловч тусдаа ялгаатай бүлгүүд ажиглагдсан учир энэ дээр түшиглээд варианцын шинжилгээ хийж үзсэн. Бүлгүүд хоорондоо ялгаатай байгаа эсэхийг ANOVA ашиглан шалгасан. P-гийн утга нь $\alpha=0.05$ -аас эрс бага буюу нойл арван мянганы ес утгатай гарсан учраас бүлгүүд хоорондох дундаж нь бол статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай гарч ирсэн. Энэ ажлаар сонгодог β -эргэлтийн 9 төрлийн дигедрал (ϕ , ψ) өнцөг болон устөрөгчийн холбоог тодорхойлсон. Сонгодог β -эргэлтийн төрлүүдийг тодорхойлох үндсэн хэмжигдэхүүнүүдийг харахад өнцгийн утгууд IV төрлийн β -эргэлтээс бусад төрөлд тогтвортой гарсан. Нийт 1315 IV төрлийн β -эргэлтийн 92.09 хувь нь устөрөгчийн холбоотой боловч (ϕ , ψ) өнцгийн түгэлт статистикийн хувьд ялгаатай байгааг ажигласан. Мөн түүний захын хоёр амин хүчлийн хоорондох d зайн түгэлт асимметр гарсан. Иймд β -эргэлтийн IV төрлийг дахин ангилах боломжтой байна.

Түлхүүр үг: Уураг, уургийн хоёрдогч бүтэц, β -эргэлт, амин хүчил
Удирдсан: Д.Батхишиг, МУБИС

Хувь хүний суралцах хэв маягт тохирсон хиймэл оюунд суурилсан ухаалаг системийн нэгэн хувилбар

Хүрлээ Хүслэн, Ганболд Дагвадорж, Батнасан Болормаа
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик Байгалийн Ухааны
Сургууль, Мэдээлэл зүйн тэнхим
lmegaaa24@gmail.com

Хураангуй. Өнөө үед боловсролын салбарт хувь хүний суралцахуйн ялгаатай хэв маяг, онцлогийг хүлээн зөвшөөрч, үнэлэх хандлага давамгайлж байна. Технологи хөгжихийн хэрээр суралцагч бүрд тохирох арга барилаар нь мэдлэгийг эзэмшүүлэхэд дэлхий нийтээр анхаарлаа хандуулж байгаа хэдий ч олон хэлбэрийн материал бэлдэхэд багшаас цаг хугацаа, нөөц ихээр шаардсан хэвээр байна.

Ялангуяа цар тахлын үеэр дэлхий даяар цахим сургалт руу шилжихэд видео агуулга бэлдэх нь багшаас нөр их хөдөлмөр шаардсан ажил болохыг нийтээр хүлээн зөвшөөрчээ. Бид энэ ажлаараа суралцагчийн хэв маягийг VARK (Харах, Сонсох, Унших/Бичих, Хөдөлгөөнөөр) загвараар тодорхойлж, тохирох сургалтын агуулгыг багшийн бэлтгэсэн үндсэн текст контентоос хөрвүүлж үүсгэх буюу санал болгох системийг бүтээхээр зорилоо. Мэдээлэл зүйн тэнхимийн 67 оюутнаас суралцах хэв маягийн оношилгоо хийдэг стандарт аргачлалаар судлахад V болон A хэв маяг давамгайлсан байна. Бидний санал болгож буй "Хувь хүний суралцах хэв маягт тохирсон хиймэл оюунд суурилсан ухаалаг системийн нэгэн хувилбар" нь багшаас аль болох бага хөдөлмөр зарцуулан, багш нарт хамгийн түгээмэл байдаг текст агуулгыг ашиглан контентыг уншиж сонгох (Chimege API ашиглах) буюу түлхүүр үгэнд тулгуурлан видео агуулга санал болгох (Youtube API ашиглах)-оос гадна машин сургалт ашиглан багшийн бэлтгэсэн текст агуулгаас асуулт, хариулт бүхий үнэлгээний материал үүсгэх, суралцагчийг дэлгэцтэй харьцах үед нүдний хөдөлгөөнийг мөшгөх замаар анхаарал сарнилтыг тодорхойлох боломжтой юм. Системийг хэрэглээнд нэвтрүүлбэл суралцагчийн суралцах хэв маягийг судалж, түүнд тохирсон арга зүй, материалыг санал болгож ашигласнаар сургалтын чанар, үр дүнд эерэг нөлөө үзүүлэх түлхүүр болох юм. Хамгийн чухал нь багш нар хичээлийн агуулгыг олон хэлбэрээр бэлтгэх ачааллыг хөнгөвчлөх боломжийг олгоно. Эцсийн дүндээ суралцагчийн амжилтад нөлөөлөх хүчин зүйлийг илүү оновчтой удирдан зохион байгуулахад чухал хувь нэмэр оруулна.

Түлхүүр үг: VARK, машин сургалт, хиймэл оюуны хэрэгсэл
Удирдсан: Ч.Долгоржав, МУБИС

Тэгш хамруулан сургах боловсролд сургуулийн удирдлагын оролцоо
(ЕБС-ийн жишээн дээр)

Даваадорж Номин
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм, Хүмүүнлэгийн
ухааны сургууль, Нийгмийн ухааны тэнхим
davaadorjnomin21@gmail.com

Хураангуй. Тусгай хэрэгцээт сурагчдыг боловсролд тэгш хамруулах нь олон улсын болон Монгол Улсын хэмжээнд боловсролын бодлогын нэг чухал чиглэл болж байна. Гэвч манай улсад 2023 оны байдлаар 20.548 хүүхэд тодорхой шалтгааны улмаас сургуульд хамрагдаж чадахгүй байгаа нь тус бодлогын хэрэгжилтэд хүндрэл байгааг харуулж байна. Тэгш хамруулан сургах боловсролоор тэргүүлж буй улс орнуудын туршлагаас харахад сургуулийн удирдлагын үүрэг, оролцоо чухал нөлөө үзүүлж байгаа тул уг сэдвийг хөндөж судалсан билээ. Судалгааны зорилго нь Монгол Улсад Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг ЕБС-д тэгш хамруулан сургахад удирдлагын үүрэг, оролцоо ямар түвшинд байгааг судалж, сайжруулах арга замыг санал болгоход оршино. Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд судалгааг сургуулийн удирдлага болон багш нараас ганцаарчилсан ярилцлага, ахлах ангийн сурагчдаас асуулгын аргаар хийж, орон нутаг, хотын төв, хотын зах болон хувийн сургуулиудын түвшинд харьцуулан судаллаа. Судалгааны үр дүнгээс товч дурдвал сургуулийн удирдлагууд тэгш хамруулах бодлогыг дэмждэг боловч бодит хэрэгжилт дутмаг, багш удирдлагын мэдлэг ойлголт нэгдмэл бус байгаа бөгөөд хотын зах болон орон нутгийн сургуулиудад сургалтын орчны хүртээмжийн асуудал нэн тэргүүнд тулгарч байна. Багш нар тусгай хэрэгцээт сурагчидтай ажиллах чадвар, сургалтын арга зүйн хувьд дутмаг гэж үзэж байгаа бол эцэг эхчүүд, сурагчдын мэдлэг төсөөлөл, оролцоо хангалтгүй байгаа нь томоохон бэрхшээл болж байна. Тэгш хамруулан сургах боловсролыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд сургуулийн удирдлагууд бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, энэ чиглэлд багш ажилчдын мэдлэг ойлголт, арга зүй, чадавхыг нэмэгдүүлэх тал дээр анхаарах, сургалтын орчны хүртээмжийг сайжруулах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Сурч боловсрох эрх, тэгш хамруулан сургах боловсрол, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд, сургуулийн удирдлага, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ), сургуулийн дэмжлэгийн баг

Удирдсан: Л.Сарангэрэл, МУБИС

“Хүргэдэд талбих” заншлын үүсэл, хувирал, үлдэц

Гэрэлтуяа Ундрах

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм, Хүмүүнлэгийн
ухааны сургууль, Түүхийн тэнхим

undrahu415@gmail.com

Хураангуй. Монголын түүхийн чухал эх сурвалж МНТ-д “хүргэдэд талбих” хэмээх заншлын тухай товч мэдээ бий. Манай ахмад эрдэмтэд бүтээлдээ “хүргэдэд талбих”-ын заншлыг хөндөж, утга агуулгыг товч авч үзсэн байна. Харин уг заншлын үүсэл гарал, хувирал, үлдцийг анхаарч судалсан зүйл бага байна. “Хүргэдэд талбих” заншлын үүсэл, хувирал, хэлбэр, үлдцийг тодруулахад оршино. Судалгааны ажлыг түүхийн мэдээ баримтыг задлан шинжлэх, харьцуулан жиших, нэгтгэн дүгнэх зэрэг судалгааны түгээмэл арга хэрэглэв. МНТ-нд бичсэнээр “Есүхэй баатар Бөртэг үзэж, охиныг гуйваас Дэй сэцэн олонтоо юү гуйлгаж өгвөөс дээжлэгдэх, цөөнтэй юү гуйлгаж өгвөөс доромжлогдох, охин хөвүүний заяан төрсөн үүдэнд өтлөх үгүй. Охиноо бээр өгсү, хөвүүнээ бээр хүргэдэд талбиж од гэхэд зөвшөөрч хөвүүнээ хүргэдэд талбиад оддог”. Дунд үеийн монголчуудын “хүргэдэд талбих” заншлыг тодруулахад, үүсэл, хувирлын гурван үе мэдэгдэж байна. 1.Эхийн эрхт овгийн байгууллын үед харь овогт хүргэн орох ёсоор уг заншлын үүсэл тавигджээ. 2.Монголын баатарлаг туульсаас үзэхэд хүрэл, түрүү төмрийн үед харь овгоос эхнэр сонгон авахад зарим тохиолдолд эрчүүд хүч чадал, авхаалж самбаа, цэц мэргэнээ сорин өрсөлдөх болсон. Энэ нь “хүргэдэд талбих” заншлын эртний уугуул хэлбэр бололтой. Үүнтэй зэрэгцэж нэг гэрт нэг хүргэн соригдох хэлбэр бий болжээ. 3.Эртний хятад сурвалжийн мэдээг баримталбал, эртний улсуудын үед хүргэн орж буй залуу охины гэрт сууж өрх гэр, мал аж ахуйн ажилд зарагдаж туслах хэлбэрээр соригддог болжээ. Энэ хожим болтол үргэлжилсэн бөгөөд үүнийг монголчууд “Хүргэн хүү хүчээ, хүргэгч гүү шимээ” зэргээр хэлэлцдэг болжээ. МНТ-ны мэдээг шинжилбэл, хоёр тал ураг барилдахыг харилцан зөвшөөрсөн тохиолдолд хүүг бага насанд нь охины талд “хүргэдэд талбин” үлдээж ээнэгшин дасгадаг байжээ. Хүннү, Сяньби, Жужаны нийгэм XII зууны Монголын нийгэмтэй үндсэндээ ижил учир энэ заншил Монголын эртний улсуудад ч байх бололцоотой. Тэгэхдээ энэ үед нэг гэрт олон хүргэд соригдох, нэг гэрт нэг хүргэн соригдох хоёр хэлбэр байжээ. Яваандаа нэг гэрт олон хүргэд соригдох явдал гээгдэж, нөгөө хэлбэр үлджээ. Энэ тохиолдолд хүргэнийг сорих сорилтууд өөрчлөгдсөн бөгөөд үлдэц нь монголчууд дунд хадгалагдсаар байна.

Түлхүүр үг: Экзогам, эцгийн эрхт ёс, хүргэдэд талбих

Удирдсан: А.Алтанбагана, МУБИС

Монгол хэлний үйл үгийн утгын өргөслийг судлах нь

(“ор”- үйл үгийн жишээн дээр)

Цэдэндамбаа Сувд-Эрдэнэ

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн
ухааны сургууль, Монгол хэлний тэнхим

suvdaa0821@gmail.com

Хураангуй. Нэг талаас үгийг бүтэц хэл шинжлэлийн үүднээс судалсан судалгаа олон байдаг ч хэлний хэрэглээний олон янз байдлыг тусгасан утгын тухай судалгаа ховор байна. Нөгөө талаас олон хэл

хоорондын машин орчуулга, цахим технологи хөгжиж буй орчин үед хэлний нэгжүүдийн утга, утгын өргөслийг тайлбарласан энэ төрлийн судалгаа цаашид чухал ач холбогдолтой учраас энэхүү сэдвийг сонголоо. Монгол хэлний “ор-” хэмээх үйл үгийн утгын давтамжийг гаргаж, утгын хүрээ, утгын өргөслийг тодорхойлон тайлбарлахыг зорилоо. Ажиглах, ангилах зэрэг, анализ, синтез зэрэг онолын судалгааны аргыг ашигласнаас гадна Хавсарга хэл шинжлэл (Applied linguistics)-ийн ухааны нэгэн төрөл болох компьютер хэл шинжлэл, түүний дотроос корпус хэл шинжлэлийн аргаар судалгааны баримт түүврийг цуглуулж, танихуйн хэл шинжлэлд түлхүү хэрэглэгддэг загварчлах аргыг тус бүр ашиглав. Монгол хэлний “ор-” хэмээх үгийн үндсэн болон салаа утгыг Сэцэнцогт-ын Язгуурын толь бичиг; Я. Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 1966 он; “Монгол хэлний гучтын тайлбар толь” 2013 он; “Монгол хэлний хорин наймтын тайлбар толь” 2013 он; ШУА-ХЗХ “Монгол хэлний их тайлбар толь” 2022 оны толь бичгүүд дэх утгад тулгуурлан давтамжаар нь тодруулав. Ингэхэд “ор-” хэмээх үгийн үндсэн утга нь: *Хүн амьтан юмны гадна талаас дотогшилох ил байдлаас далд болох шилжих орны утга юм*. Үүнээс гадна салаа утгын 15, олдмол утгын 5 хүрээгээр тус бүр хэрэглэгдэж хэвшсэн нь дээрх судалгааны үр дүнд харагдаж байна. “Ор-” хэмээх үйл үгийн үндсэн болон салаа утгыг толь бичгүүдийн утгатай харьцуулан тодруулж, “Уран зохиолын дээж” (108) ботийн 7.880.161 үгтэй цахим сангийн баримтад тулгуурлан, нийлмэл нэгжийг түүвэрлэн ангилж, утгын хүрээг тодруулав. Цахим сангийн баримтад “ор-” хэмээх үйл үгийн шууд утгаараа хэрэглэгдэж буй давтамж хамгийн өндөр хувийг эзэлж байна. Түүвэрлэсэн баримтуудыг ажиглаж, дүн шинжилгээ хийхэд “Ор-” хэмээх үйл үг нь толь бичиг дэх 21 салаа утгаас гадна *“цаг хугацааны, хэмжээний, эрчимжүүлэх, үр дагаврын* зэрэг 4 утгалбар буюу салаа утгаар өргөсөн тэлж хэрэглэгдэж байна. Үгийн утга өргөжин тэлэхэд угсаатны онцлог, нийгэм соёлын нөлөө их байдаг ба нөгөөтэйгүүр үүнийг дагаад утга явцууран хомстох үзэгдэл ч тохиолдож болно. Үгийн утга, утгын өргөслийг тодруулахдаа тэдгээрийн бүтэц, хэл зүйн хэлбэр, хам сэдэвт тулгуурлан судалбал илүү оновчтой, үр дүнтэй болох нь ажиглагдлаа. Судалгааны үр дүнгээс ажиглахад ихэвчлэн жинхэнэ нэрийг захирч салаа утгын олон хүрээ үүсгэж байсан бол үйл үгтэй холбогдож хэрэглэгдэхдээ зөвхөн нэг утга илэрхийлж туслах үйл үгийн үүргээр тохиолдож байсан юм. Ийнхүү шинэ утгын хүрээг үүсгэхдээ мөн дээр дурдсанчлан нэр үгийг захирч, харилцан адилгүй нөхцөлөөр хэлбэржиж утгын хүрээг өргөсгөн тэлж байна. Утга өргөжин тэлэхэд хүн ба юм үзэгдлийн хэрэглээ, хэрэгцээ, шинж чанар, зориулалт нөлөөлж байна хэмээн үзэж байна.

Түлхүүр үг: Утга, үндсэн утга, салаа утга, шилжсэн утга, утгын хүрээ

Удирдагч: Р.Сарангэрэл, МУБИС

Гурван настай хүүхдийн математик энгийн төсөөлөл чадварыг гар утасны тоглоом ашиглан хөгжүүлэх нь

Анхбаяр Хонгорзул

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,

Боловсрол судлал, арга зүйн тэнхим

hovsgolsaihanhongorzul@gmail.com

Хураангуй. Хүүхдийн математик сэтгэлгээний суурь нь тэдний амьдралын эхэн үед тавигддаг. Тэд аажмаар цаг хугацаа орон зайтай холбоотой анхны туршлагаа олж авч хэмжих, тооцоолох, ангилах, харьцуулах зэрэг суурь математик үйлдлүүдийг таньж эхэлдэг. Мөн хүүхэд 3 нас хүрэхэд тоолох логик зарчмуудыг ойлгож эхэлдэг бөгөөд тоо болон тоон үзэгдлүүд нь хүүхдүүдийн сонирхлыг маш эртнээс татдаг байна. Өнөөгийн нийгэмд зургаан сартайгаасаа эхлэн ухаалаг утас, таблет, компьютер зэрэг дижитал төхөөрөмж нь тэдний өдөр тутмын амьдралд давамгайлж байгаа тул бага насны хүүхдүүд дижитал ертөнцөд өсөн торниж байна. Хүүхдүүд гар утас, ухаалаг төхөөрөмжид нэн сайн дассан ба шинэ үеийн хүүхдүүдийн хувьд дижитал хэрэглээ нь хүүхдийн хөгжлийн шинэ суурь,

суралцах орчин болж байна. Иймээс бид хүүхдүүдээ дижитал орон зайгаас таслах гэсэн дэмий оролдлогуудыг орхиж, тэдэнд эерэг байдлаар хөгжихөд нь туслахад илүү анхаарах ёстой юм. Гар утасны тоглоом хүүхдийн сурч боловсрох, хөгжилдөх арга замыг хурдацтай өөрчилж байгаа бөгөөд хүүхдүүдэд бодит ертөнцөд оролцож, жинхэнэ суралцах туршлагыг бий болгох маш олон боломжийг нээж өгдөг. Гол зорилго нь боловсролын нөхцөлд гар утасны тоглоомыг нэвтрүүлэх шинэ аргыг дэмжих явдал юм. Эдгээр технологиуд нь сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан хөгжлийн тохиромжтой боловсролын эх үүсвэр болж улам хүлээн зөвшөөрөгдөж байна. Иймд гар утас тоглоомыг зөвхөн цаг өнгөрөөх хэрэгсэл биш, харин мэдлэг олж авах, чадвараа хөгжүүлэх хэрэгсэл болгон ашиглах нь чухал бөгөөд гурван настай хүүхдүүдийн математик энгийн төсөөллийг тогтоож боловсролын орчинд гар утасны тоглоомыг нэвтрүүлэн хүүхдийн математикийн суурь мэдлэгийг үр дүнтэй хөгжүүлэх, тэдний төсөөлөх, сэтгэх чадварыг нэмэгдүүлэх арга зүй, технологийг гүнзгийрүүлэн судалж дэмжих нь зайлшгүй шаардлагатай болж байна.

Түлхүүр үг: Гурван настай хүүхдийн онцлог, математик энгийн төсөөлөл, гар утасны тоглоом
Удирдсан: Л.Ариунжаргал, МУБИС

Үндэсний бичгээр уншиж, ойлгох чадварын судалгаа (ЕБС-ийн X ангийн сурагчдын жишээн дээр)

Энхбаяр Аззаяа
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим
enhbayarazzaya93@gmail.com

Хураангуй. Монгол бичиг нь Монголчуудын түүх, соёл, оюуны дархлааг илэрхийлсэн олон зуун жилийн уламжлалтай, үнэт өв юм. Монгол бичиг нь Монгол улсын үндсэн хуулиар баталгаажсан боловч түүний өдөр тутмын амьдралд гүйцэтгэх үүрэг бага байгааг анзаарч Монгол бичиггүйгээр Монгол Улс байх боломжгүйг ухааран өдөр тутамдаа хэрэглэн үндэсний сэтгэлгээгээ бэхжүүлэн, тусгаар оршихуйгаа баталж, даяаршлын цаг үед дангаарчлалаа авч үлдэхийн төлөө Монгол хүн бүр хичээн чармайхгүй бол болохгүй мөч ирснийг ухамсарлах нь чухал байна. Сүүлийн жилүүдэд үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор төрийн бодлого, хөтөлбөрүүд олноор хэрэгжиж байна. Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөр III-ийн хүрээнд 2025 оны 01 дугаар сарын 01-ээс эхлэн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөх зохицуулалт хэрэгжиж эхэлсэн. “Алсын хараа 2050-Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын зорилт 1.3 нь “Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ” гэж заажээ. Судалгааны үндсэн асуудлын хүрээнд иргэн бүр хууль тогтоомжийг дагаж мөрдөхөөс гадна түүх, соёлоо ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээхэд хувь нэмрээ оруулах шаардлагатай байна. Энэхүү судалгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн X ангийн сурагчдын үндэсний бичгээр уншиж, ойлгох чадварыг судалж, үр дүнг илрүүлэх зорилготой. Судалгаа нь асуулгын болон туршилт гэсэн үндсэн хоёр аргаас бүтсэн. Асуулгын судалгаанд БЗД-ийн А сургуулийн X ангийн 95 сурагч болон СХД-ийн Б сургуулийн X ангийн 109 сурагч нийт 204 сурагч (эрэгтэй-89, эмэгтэй-115)-ийг хамрагдсан бөгөөд туршилт судалгаанд БЗД-ийн А-р сургуулийн X ангийн 94 сурагч хамрагдсан. Судалгааны үр дүнд сурагчдын нэг минутад унших чадвар хангалтгүй, танил эхийг нэг удаа бүрэн уншихын тулд хугацаа их зарцуулж байна. Эхийн агуулгыг ойлгох чадварын хувьд, нийт сурагчдын зөв хариулсан асуултын дундаж 2, ойлголтын дундаж хувь 35% байна. Сурагчдын зөв хариулт өгөх түвшин буурах тусам эхийг бүрэн дүүрэн уншиж ойлгоогүй, анхаарал төвлөрөл сул, унших чадвар сул байгааг харуулж байна. Тодруулбал, 4.25% нь бүх асуултад зөв хариулсан (маш сайн ойлгосон); 95.75% нь гол санааг өөрийн үгээр дүгнэх чадвар сул; 91.5% нь зохиолчийн гол санааг дэлгэрүүлсэн хэсгийг олж тайлбарлах чадвар сул; 85.1% зохиолчийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр, хэсгийг ялгах чадвар сул; 74% нь үйл явдлын нөхцөл, шалтгаан, холбоо хамаарлыг тогтоох чадвар сул байна. Судалгаанд оролцогчдын 8.51% нь бие даасан уншигч буюу маш сайн уншиж, ойлгодог, 6.38% нь

тусламж шаардлагатай уншигч буюу уншиж, ойлгох чадвар дундаж, дийлэнх сурагчид уншиж, ойлгох чадвар маш хангалтгүй байна. Х ангийн сурагчдын уншиж, ойлгох чадвар хангалтгүй түвшинд байгаа нь тэдний цаашдын хичээл судлал, эх хэлний бичгийн боловсрол, бие даан суралцах чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Иймд унших чадварыг системтэй хөгжүүлэх, уншлагын арга зүйг оновчтой болгох, хэл зүйн мэдлэгийг бэхжүүлэх зэргээр сургалтын үр дүнг дээшлүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Сурагчид, үндэсний бичиг, уншиж ойлгох чадвар

Удирдсан: Чү.Байгалмаа, МУБИС

Сурагчдын бие даан суралцах чадварт метакогнитив суралцахуйн үзүүлж буй нөлөө

Галбадрах Сүнжидмаа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,

Боловсрол судлал, арга зүйн тэнхим

sunjeesunjidmaa177@gmail.com

Хураангуй. XXI зуунд боловсролын гол зорилго нь суралцагчийг өөрийн сурах үйл явцыг удирдах, бие даан хөгжих чадамжтай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэж байна. Энэхүү судалгааны зорилго нь ахлах ангийн сурагчдын метакогнитив суралцахуйн түвшин нь тэдний бие даан суралцах чадварт хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох явдал юм. Судалгаанд Улаанбаатар болон орон нутгийн 10-12-р ангийн 292 сурагчийг хамруулж, метакогнитив мэдлэг болон зохицуулалтын хэмжүүр бүхий MAI асуулгыг хэрэглэсэн. Мөн асуулгын дундаж үзүүлэлт дээр үндэслэн “сайн, дунд, сул” ангилсан 9 сурагчтай хагас бүтцэт ярилцлага хийв. Өгөгдлийг SPSS 29.0 программ ашиглан Cronbach’s Alpha, корреляци, регрессийн шинжилгээгээр боловсруулсан. Үр дүнд метакогнитив мэдлэг ($\beta=.404$, $p < .001$), хяналт ба зохицуулалт ($\beta=.393$, $p < .001$) нь бие даан суралцах чадварт статистикийн хувьд ач холбогдол бүхий эерэг нөлөөтэй болох нь тогтоогдсон. Хамаарлын шинжилгээгээр эдгээр хувьсагчид болон бие даан суралцах чадварын хооронд $r > .73$ ($p < .001$) гэсэн өндөр эерэг хамаарал илэрсэн. Чанарын үр дүнгээр сайн түвшний сурагчид суралцах үйл явцыг ухамсартайгаар төлөвлөн, хянаж байсан бол сул түвшний сурагчид тухайн үеийн нөхцөлд хариу үйлдэл үзүүлдэг байв. Судалгааны онолын үндэслэл нь Флавелл (1979)-ийн метакогнитив танин мэдэхүйн хяналт хэмээн тодорхойлсон үзэл баримтлал, мөн Зиммерманы (2002) өөрийгөө зохицуулах суралцахуйн онолд суурилсан. Энэхүү судалгаа нь эдгээр онолын хэрэгжилтийг сургалтын бодит орчинд шалгасан бөгөөд үр дүн нь багш, боловсролын байгууллагад метакогнитив чадварыг сургалтын арга зүйд үр дүнтэй тусгах онол-арга зүйн чиглэл санал болгож байна.

Түлхүүр үг: Метакогнитив суралцахуй, бие даан суралцах чадвар, MAI, ахлах анги, боловсролын арга

Удирдсан: Р.Намжилдагва, МУБИС

МСБХ-ны цахим хуудсанд нийтлэгдсэн спортын гэрэл зурагт хийсэн ажиглалт

Батбаатар Чойжамц
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Биеийн тамирын сургууль,
Биеийн тамир, спортын онол, арга зүйн тэнхим
bchoijamts186@gmail.com

Хураангуй. Спортын соёл улам бүр түгээмэл болж, загварын ертөнц, соёл, урлагийн салбарт нэвтрэн орохын хэрээр спортын гэрэл зураг нь шууд үйл ажиллагааны фото сэтгүүл зүйгээс хальж, брэнд, тамирчид, алдартнуудад зориулсан бүтээгдэхүүн, брэндийн зураг, редакцын болон загварын, арилжааны гэхчлэн гэрэл зургийн салбар өргөжин тэлсээр байна. Монголын Сагсан бөмбөгийн холбооны албан ёсны цахим хуудсанд нийтлэгдсэн спортын гэрэл зургийн онцлогийг тодорхойлохыг зорьсон. Судалгааны ажлын хүрээнд МСБХ нь спортын төрөлжсөн холбооны сайтад фото сэтгүүл зүйн үндсэн 5 дэд ангилал буюу хөрөг зураг 7.3%, онцлох зураг 13.4, мэдээний зураг 15.5% дүрслэлт зураг, зурган түүх 36.7% төрлийн фото нийтлэгддэг байна.

Түлхүүр үг: Спортын агшин, фото сэтгүүл зүй, спортын гэрэл зурагчин
Удирдсан: С.Ганцэцэг, МУБИС

Лигийн тоглолтын тайлбарлагчдын ур чадварт хийсэн ажиглалт

Юмжин Наранцогт
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Биеийн тамирын сургууль,
Биеийн тамир, спортын онол, арга зүйн тэнхим
ymjinnarantsogt2@gmail.com

Хураангуй. Сагсан бөмбөгийн спорт нь зөвхөн хоёр багийн хоорондох тоглолт биш мөн үзэгчид болон сагсан бөмбөгийн тайлбарлагчдын хоорондын харилцаа юм. Сагсан бөмбөгийн тоглолтыг үзэж байгаа үзэгчдийн сэтгэл хөдлөл, урам зоригийг өдөөж, тухайн тоглолтын уур амьсгалыг бүрдүүлж өгдөг гол зүйл бол тайлбарлагч юм. Тайлбарлагчид нь тоглолтын үйл явдлыг ойлгомжтой, үнэн зөв, сонирхолтой, байдлаар хүргэх үүрэгтэй. Гэвч тайлбарлагч бүрийн ур чадвар өөр өөр түвшинд байдаг. Зарим тайлбарлагч нь мэргэжлийн өндөр түвшинд тайлбарлаж байхад зарим нь мэдээлэл хүргэн тайлбарлахын хувьд үзэгч, хөгжөөн дэмжигчдийн сэтгэлд хүрдэггүй. Монголын сагсан бөмбөгийн лигийн тоглолтын тайлбарлагчдын ур чадварыг тэдгээрт тавигддаг нийтлэг шалгуурт нийцэж байгааг тогтоох зорилготой юм.

Түлхүүр үг: Сагсан бөмбөг, тайлбарлагч, ур чадвар, спортын сэтгүүл зүй
Удирдсан: С.Ганцэцэг, МУБИС

Сурагчдын суралцах хэв маягийн судалгаа

Мөнх-Эрдэнэ Нандин-Эрдэнэ
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Дүрслэх Урлаг
Технологийн Сургууль, Технологийн тэнхим
nandiamnkh98@gmail.com

Хураангуй. Энэхүү судалгаагаар Нейл Флемингийн боловсруулсан VARK-ийн аргаар сурагчдын суралцах хэв маягийг тодорхойлж, тэдэнд тохирох сургалтын аргыг судалж өөрийн арга барилд

тусгаж, сурах арга барилаа олоход нь оршино. Дизайн технологийн багш мэргэжлээр суралцаж байгаа тул сурч байх хугацаандаа суралцагчдын суралцах хэв маягийг судалж дийлэнх суралцах хэв маягийг тодорхойлж тэрхүү арга барилыг өөртөө суулгаж заах арга барилаа олж авах юм. Нейл Флемингийн боловсруулсан судалгааны арга барилыг ашиглан Google Forms ашиглан түүврийн аргаар судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс харахад харааны (Visual) хэв шинж нь илүү давамгайлсан үзүүлэлтийг харуулсан байна. Ихэнх сурагчид ой тогтоолт сайтай, сонсож, ярихаас илүү унших, бичих даалгавар хийх, өнгө, дүрслэл, хүснэгтээс мэдээлэл авахдаа илүү сайн гэдэг нь харааны хэв шинжээс нь харагдаж байна.

Түлхүүр үг: VARK арга, сурагчдын суралцах хэв маяг, хэв шинж
Удирдсан: М.Баасанбаяр, МУБИС

Хүүхдийн зурсан зургаар дамжуулж гэр бүлийн харилцааг шинжих нь

Отгонбаяр Энхжин
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Дүрслэх Урлаг
Технологийн Сургууль, Дүрслэх урлагийн тэнхим
otgonbayarenkhjin5@gmail.com

Хураангуй. Гэр бүл хүний анхны нийгмийн орчин бөгөөд хувь хүний зан төлөв, үнэт зүйл, сэтгэлзүйн онцлог бүрэлдэхэд чухал нөлөө үзүүлдэг. Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа нь зөвхөн тухайн гэр бүлийн уур амьсгал төдийгүй хүүхдийн сэтгэл зүйн хөгжил, нийгэмшилт, амьдралын чанарт шууд нөлөөлдөг тул гэр бүлийн харилцааг судлан, дүн шинжилгээ хийх нь чухал юм. Зурган тест нь үг ярианаас илүүтэйгээр хувь хүний дотоод мэдрэмж, хандлагыг илэрхийлэх боломжийг олгодог. Тиймээс зурган тест нь тэдний далд мэдрэмж, гэр бүлийн талаарх ойлголтыг тодорхойлоход үр дүнтэй арга хэрэгсэл болдог. Хүүхдийн зурсан зурагт тулгуурлан түүний сэтгэл зүй, дотоод мэдрэмж болон гэр бүлийн гишүүдтэйгээ хэрхэн харилцаж буй хандлага, ойлголтыг тодорхойлох, гэр бүлийн уур амьсгалын талаар болон хүүхдийн гэр бүлдээ эзэлж буй байр суурийг тодорхойлох зорилготой. Р.Бернс, С.Кауман нар гэр бүлийн дотоод харилцааг хүүхдийн байр сууринаас оношлоход зориулан “Гэр бүлийн хөдөлгөөнт зурган тест”-ийн аргыг ашиглан хүүхдийн 50 ширхэг бүтээл дээр туршлаа. Судалгаа хийж байх явцад хүүхдүүд өөр өөрсдийн ертөнцөөр гэр бүлээ зурсан байсан. Хүүхдүүд гэр бүлээ аялж байгаагаар, аав ээж нь хуримаа хийж байгаа гэх мэтээр сэдэвчлэн зурсан бол зарим нь “Гэр бүл” гэсэн атал өөрийгөө зураагүй орхих юм уу, аав ээжийгээ зуралгүй орхих тохиолдлууд илэрч байсан. Үүнээс үзэхэд хүүхдийн зурсан зургийг энгийн зүйл гэж тоохгүй өнгөрч болохгүй, учир нь татсан зураас, сонгосон өнгө болгонд нь тэдний цаад сэтгэл хөдлөл, мэдрэмж сэтгэгдэл нь нуугдаж байдаг. Яагаад гэвэл тэд өөрсдийгөө хэл яриагаараа бүрэн илэрхийлж чаддаггүй учраас зургаараа дамжуулж өөрт төрж буй мэдрэмжээ ил гаргадаг. Тиймээс хүүхдийнхээ зурсан зурагт анхаарлаа хандуулж, яагаад ингэж зурах болсон тухай нь сайтар асууж ярилцан, урам өгөх хэрэгтэй юм. Гэр бүлийн тогтолцоонд гажуудал үүсэж, тэнцвэрт байдал нь алдагдаж байгаа явдал нь хүүхдийн зан үйлээр тод илрэн гарч ирдэг болох нь бодитой харагдлаа. Хүүхдийн зан үйл, цаашлаад танин мэдэхүйн үйл, бусад талын хөгжил, төлөвшилд нь онцгой сөрөг нөлөөлөл үзүүлж, тэдний зан байдал өөрчлөгдсөн, сурах идэвх, сонирхол, чадвар нь эрс буурсан үзүүлэлттэй байдаг нь зурган тест, ярилцлагаас тодорхой илэрч байлаа. Үүнийг зөв оношлон, илрүүлж чадсанаар зөвлөгөөг зөв чиглүүлэх, улмаар хүүхдийн зан үйлийн сөрөг онцлогийг зарцуулах боломжтой юм гэж дүгнэлээ.

Түлхүүр үг: Зурган тест, гэр бүлийн харилцаа, хандлага
Удирдсан: Т.Сэлэнгэ, МУБИС

STEM хичээлийн төлөвлөлт, туршилтын үр дүнд хийсэн шинжилгээ

Лувсандэмбэрэл Ануужин
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Дүрслэх Урлаг
Технологийн Сургууль, Технологийн тэнхим
anujina203@gmail.com

Хураангуй. Боловсрол судлаачид хичээлд ажиглалт хийхийг чухалчилдаг бөгөөд хичээл төлөвлөлт, хэрэгжилтийн явц дахь анхаарах асуудлыг бусадтайгаа хуваалцсанаар суралцахуйн эерэг үр дүнд хүрэх боломжтой гэж үздэг байна. Хичээлийн төлөвлөлт, заах аргыг сонгох, хүргэх зохимжтой хэлбэрийг ашиглах, үнэлэх аргачлал зэргээс сургалтын үр дүн шууд хамааралтай байна. Эдгээрийг тодруулах зорилгоор STEM хэрэглэгдэхүүнд тулгуурлан төлөвлөж заасан хичээлийг жишээлэн судалж, гаргасан дүгнэлтийг энэхүү судалгааны ажлаараа дэвшүүлэн хэлэлцүүлэх зорилго тавьсан болно.

Түлхүүр үг: STEM хэрэглэгдэхүүн, хичээл ажиглалт, сургалтын үр дүн
Удирдсан: Д.Сэрээтэрдорж, МУБИС

Тавдугаар ангийн сурагчдын геометрийн агуулгын хүрээнд эзэмшсэн мэдлэг чадварыг үнэлэх арга зүй

Алтангэрэл Дарханцэцэг
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Багшийн сургууль, Бага боловсролын
математик, байгалийн ухааны тэнхим
darhantsetsegdarhantsetseg@gmail.com

Хураангуй. 5-р ангийн сурагчдын геометрийн агуулгаар эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлгээний арга зүйгээр үнэлж, түүнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. Судалгааг математикийн сургалтын онол, арга зүйн талаарх ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл, цахим материалуудыг судлах, Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн математикийн сургалтын хөтөлбөр, стандартыг судлах зэрэг арга зүйгээр явуулсан. Энэхүү өгүүлэлд тавдугаар ангийн сурагчдын геометрийн агуулгаар эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх арга зүйг боловсруулж, бодит сургалтын орчинд туршин үнэлгээний үр дүнд дүн шинжилгээ хийсэн. Судалгааны онолын үндэс нь Жан Пиажегийн танин мэдэхүйн хөгжлийн үе шатны онол болон Ван Хиелийн геометрийн сэтгэлгээний түвшний загварт тулгуурлаж, бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөр дэх геометрийн агуулгын залгамж холбоо, суралцахуйн үр дүн, шалгуурт суурилсан үнэлгээний системийг нарийвчлан судалж, үнэлгээний хэрэгсэл (тест, даалгавар) боловсруулах, турших замаар сургалтын чанар, үнэлгээний арга зүйг сайжруулах арга замыг эрэлхийлсэн.

Түлхүүр үг: Геометрийн мэдлэг, чадвар, Жан Пиажегийн танин мэдэхүйн онол, Ван Хиелийн онол, шалгуурт суурилсан үнэлгээ
Удирдсан: А.Гантуул, МУБИС

Дижитал технологийг үр дүнтэй ашиглаж буй өнөөгийн байдал
(Бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын жишээн дээр)

О.Цэндсүрэн, А.Дуламсүрэн, Б.Нэргүй, О.Энхзул
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Багшийн сургууль, Бага боловсролын
нийгмийн ухаан, монгол хэлний тэнхим
tsegt4128@gmail.com

Хураангуй. Мэдээлэл, харилцаа холбооны технологи хурдацтай хөгжиж буйтай холбоотойгоор технологийн дэвшил нь хүмүүсийн ажиллах, суралцах, харилцах арга барилд хүчтэй нөлөө үзүүлж байна. Энэ өөрчлөлт нь дижитал ур чадварыг зайлшгүй шаардлагатай болгож байгаа бөгөөд багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд мэдээлэл технологийн хэрэгслийг хэрхэн эзэмшиж, ашиглаж буй түвшинг судлах нь чухал ач холбогдолтой юм. Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн (МУБИС) Бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын дижитал ур чадварын түвшинг тодорхойлох, дээд боловсролын түвшинд дижитал технологийг хэрхэн идэвхтэй ашиглаж байгааг судлах явдал юм. Судалгааг МУБИС-ийн Багшийн Сургуулийн Бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын дунд явуулсан бөгөөд оюутнууд дижитал технологийг суралцах үйл ажиллагаандаа хэр үр дүнтэй ашиглаж байгааг тодорхойлоход чиглэсэн. Судалгаанд нийт 80 оюутан хамрагдсан бөгөөд асуумжийн аргыг ашиглан судалгааг онлайн хэлбэрээр зохион байгуулсан. Асуумж нь 12 нээлттэй болон хаалттай асуултаас бүрдэж, оюутнуудын дижитал технологийн мэдлэг, ур чадвар, ашиглалтын түвшинг үнэлэхэд чиглэсэн.

Түлхүүр үг: Дижитал ур чадвар, оюутнууд, суралцахуй

Удирдсан: Н.Оюунтунгалаг, МУБИС

Монтессори сургалтын арга зүйг туршсан үр дүн

Сүрэнхорол Цэрэнбадам
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Сургуулийн өмнөх
боловсролын сургууль, Арга зүйн тэнхим
stserenbadam971@gmail.com

Хураангуй. Тус илтгэлд Монтессори сургалтын арга зүйн мэдрэхүйн хөтөлбөрийг таван настай хүүхдийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг судалсан үр дүнг танилцуулж байна. Мэдрэхүйн хөтөлбөр нь хүүхдийн таван мэдрэхүйн эрхтэн болох харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүрэлцэх чадварыг хөгжүүлж, танин мэдэхүй, бие даасан байдал, сэтгэхүйг дэмждэг онцлогтой. Судалгаанд Нийслэлийн Баянгол дүүргийн 93 дугаар цэцэрлэгийн хоёр бүлгийн нийт 12 хүүхдийг хамруулж, ажиглалт, туршилтын аргаар Монтессорийн сургалтын мэдрэхүйн хэрэглэгдэхүүнийг ашиглан, хүүхдийн хөгжилд гарсан ахиц өөрчлөлтийг ажиглан тэмдэглэсэн. Үр дүнд нь мэдрэхүйн чадамж, бие даан ажиллах, логик сэтгэлгээ зэрэг чадварууд сайжирсан нь харагдсан. Иймд Монтессори сургалтын мэдрэхүйн хөтөлбөрийг сургуулийн өмнөх боловсролын түвшинд амжилттай хэрэгжүүлэх боломжтойг энэхүү судалгаа харуулж байна. Монтессори цэцэрлэгт хэрэгжүүлдэг арга зүйг бусад цэцэрлэгт хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлах, хүүхэд аливаа зүйлийг таван мэдрэхүйгээрээ хүртэж үзсэнээр ямар ач холбогдолтой чухал талаар судалсан байна. Иймд тус боловсролын арга зүйн мэдрэхүй хөтөлбөрийг сонгон авч, таван насны хүүхэд дээр туршин хэрэгжүүлэхээр сонгон авлаа. Монтессори сургалтын арга зүй, мэдрэхүйн хөтөлбөрийг таван настай хүүхдэд туршин хэрэгжүүлснээр хүүхдийн хөгжилд гарч буй ахиц, өөрчлөлт, үр нөлөөг үнэлсэн онол-практикийн судалгаа юм. Монтессори арга зүйн гол үр дүн хүүхэд өөрөө суралцах, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх, туршин танин мэдэх, чөлөөтэй байх орчин, хүлээцтэй байдал, ёс зүйн төлөвшил, анхаарал төвлөрөл гэх мэт бүх чадварыг цогцоор нь хөгжүүлж байна.

Түлхүүр үг: Хүүхэд, туршилт судалгаа, мэдрэхүйн хөгжил, мэдрэхүйн хөтөлбөр

Удирдагч: Д.Мягмар, МУБИС

3-4 настай хүүхдийн хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх боломжийг судалсан нь

Болдбаатар Сарангэрэлмаа
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Сургуулийн өмнөх
боловсролын сургууль, Гоо зүйн тэнхим
saraa.03b@gmail.com

Хураангуй. Хөгжмийн сургалтын онолын үндэслэгчид бага насны хүүхдийн хөгжилд хөгжмийн боловсрол нь чухал гэж тодорхойлсон байдаг бөгөөд хүүхдийг хөгжимчин болж хөгжүүлэх бус харин хөгжмөөр дамжуулж сайн шударга хүн болгож хүмүүжүүлэх хэрэгтэй гэж үзсэн. Мөн хөгжим бол хүний сэтгэлд хүрч чадах цорын ганц зэвсэг, хөгжимлөг биш хүүхэд гэж байдаггүй хүүхэд бүр хөгжимлөг авьяас чадвартай гэж үздэг. Хөгжим нь сэтгэхүйн чанартай, гүн ухаан амьдралын утга учрыг эгшгээр илэрхийлдэг сэтгэлгээний урлаг учраас хүүхдийн оюун ухаан, сэтгэцийн ерөнхий хөгжлийг хангах, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх чухал хэрэглүүр болдог. Бага насны хүүхэд хөгжмөөр дамжуулж хөгжмийн сонсголоос гадна танин мэдэхүй, хэл ярианы хөгжил цаашилбал анхаарал, ой тогтоолт, дүрслэн бодохуй, гоо сайхны мэдрэмж, хөдөлгөөний эвсэл, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх олон талын үр нөлөөтэй. Карл Орф хүүхдийг жирийн өдөр тутмын хөдөлгөөн, яриа, тоглоом, дуу, хөгжим зэргийг ашиглан байгалийн жамаар хөгжмийн боловсрол эзэмших боломжтой гэж үзсэн. Энэхүү судалгаанд Карл Орфын хөгжмийн боловсролын онол арга зүйд тулгуурласан 3-4 настай хүүхдэд тохирсон Орфын энгийн хөгжмийн зэмсэг ашиглан хэмнэлийг тоглож сургах, хэмнэлийг дагах, хүүхдийн хөгжмийн суурь авьяас чадварыг тодорхойлох дасгал даалгавар боловсруулан сургалт үйл ажиллагаа зохион байгуулж, хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх боломжийг судлах судалгааг зохион байгуулсан. Мөн байдлыг тогтоох судалгааг авсны дараагаар хүүхдүүдийн хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх, дасгал аргачлалыг боловсруулан үүнийхээ дагуу өндөрлөгтэй, өндөрлөггүй хөгжмийн зэмсгүүд болох кастанет, цагирагт болон бариултай хонх, эгшигт хонх хөгжмүүдээр хүүхдийн хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх хялбар дасгалууд 14 хоногийн хугацаанд хийлгэсэн бөгөөд үүний дараагаар ахицын судалгааг авч гарсан үр дүнг нэгтгэн 3-4 настай хүүхдийн хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал нь юу байгааг өөрийн үзэл дээр суурилан дүгнэж, хэрхэн хөгжүүлэх боломжтой байгаа талаар өгүүлэв.

Түлхүүр үг: Хэмнэлийн мэдрэмж, хөгжмийн суурь авьяас
Удирдсан: Б.Наранцэцэг, МУБИС

Залуучуудын худал мэдээлэлд итгэх нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлүүд

Баярмагнай Солонго, Булганчимэг Энхтөр
Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Архангай аймаг дахь
Багшийн сургууль, Боловсрол судлалын тэнхим
solongobaymagnai0206@gmail.com

Хураангуй. Цахим орчинд мэдээллийн урсгал эрс нэмэгдэж, худал, баталгаагүй мэдээлэл залуучуудын дунд өргөн тархах болсон нь нийгэм, сэтгэл зүйн олон сөрөг үр дагавар дагуулах болсон. Энэхүү судалгааны зорилго нь залуучуудын худал мэдээлэлд итгэх хандлагыг тодорхойлж, түүнд нөлөөлж буй сэтгэл зүйн хүчин зүйлсийг судлахад оршино. Судалгаанд Архангай аймагт сурч, ажиллаж, амьдарч буй 18-35 насны 32 залуучуудыг хамруулсан ба ажиглалт, асуулга, бүлгийн ярилцлага, эх сурвалжийн судалгаа зэрэг чанарын болон тоон аргуудыг хослуулан хэрэгжүүлж, өгөгдлийг SPSS болон Google Forms ашиглан боловсруулсан. Онолын үндэслэлд сэтгэхүйн онол, когнитив диссонанс, сэтгэл зүйн манипуляци, нийгмийн танин мэдэхүйн онол зэрэг үзэл

баримтлалуудыг авч үзсэн. Судалгааны үр дүнд худал мэдээлэлд итгэхэд хамгийн өндөр нөлөө үзүүлж буй хүчин зүйл нь хувь хүний сэтгэл зүйн байдал (айдас, түгшүүр) бөгөөд энэ хувьсагчийн хамаарал $r=0.750$ гэсэн өндөр үзүүлэлттэй байна. Мөн мэдээллийг хүлээн авах чадвар хувьсагч нь $r=0.692$ буюу дунд зэргийн хамааралтай байгааг харуулсан. Залуучуудын худал мэдээлэлд автах магадлал нь тэдний мэдлэг, боловсролын түвшин, мэдээлэлтэй харьцах чадвар болон тухайн үедээ мэдэрч буй сэтгэл зүйн байдлаас хамаарч ихээхэн ялгаатай байна. Иймд мэдээлэлтэй зөв харьцах дадал, эх сурвалжийг шүүх чадварыг төлөвшүүлэх нь мэдээллийн эрин үеийн зайлшгүй шаардлага гэдгийг энэхүү судалгаа баталж байна.

Түлхүүр үг: Оюутан, худал мэдээлэл,сошиал медиа, сэтгэл зүйн хүчин зүйлс
Удирдсан: Г.Нэргүйбаатар, МУБИС

**Байгууллагын стрессийн түвшинг тодорхойлон, нөлөөлөгч хүчин зүйлд
хамаарлын шинжилгээ хийсэн үр дүн**
(Боловсролын байгууллагын багш, ажилчдын жишээн дээр)

Цэрэнпүрэв Цээжаргал
Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн
Архангай аймаг дахь Багшийн сургууль, Боловсрол судлалын тэнхим
tseejargal13@gmail.com

Хураангуй. Орчин үеийн боловсролын байгууллагын гүйцэтгэлд нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг нь ажилтны сэтгэл зүйн стресс юм. Ажилтны стресс нь зөвхөн хувь хүний сэтгэлзүйд төдийгүй байгууллагын бүтээмж, хамт олны уур амьсгал, ажлын орчинд өргөн хүрээтэй сөрөг нөлөө үзүүлдэг. Тиймээс Боловсролын байгууллагын стрессийн түвшинг үнэлж, гол нөлөөлөгч хүчин зүйлсийн хоорондын хамаарлыг судлах замаар ажлын орчны сэтгэлзүйн төлөв байдлыг тодорхойлох гэсэн зорилго дээр тулгуурлаж. Боловсролын байгууллагын 100 багш, ажилтнаас, Байгууллагын стрессийн түвшинг судлахад ашигладаг сорил Jamal (1990) болон Shirom, Mayer (1993) нарын судалгааг ашиглан стрессийн түвшинг хэмжив. Хамаарлыг шинжлэхэд олон хувьсагчийн регрессийн шинжилгээ болон корреляцийн дүн шинжилгээг SPSS 25 программ ашиглан хийсэн. Судалгааны үр дүнд ажилтны стрессийн түвшинд хамгийн ихээр нөлөөлж буй хүчин зүйлс ажлын ачаалал ба стресс түвшин дундаж нь ижил (2.02), хоорондоо боломжит хамаарал байж болзошгүй. Шийдвэр гаргалт, хяналт дундажтай боловч хувь хүнээс шалтгаалан ялгаа ихтэй байна. Энэ нь регрессийн шинжилгээнд стрессийн гол нөлөөлөгч болж гарсан. Урамшуулал, дэмжлэг хамгийн бага оноотой хувьсагч энэ нь байгууллагын дотоод соёл, ажилтны сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж байж магадгүй. Стресс түвшин нь олон хүчин зүйлээс хамаарч хувь хүмүүсийн дунд нэлээн ялгаатай байгаа нь анхаарах ёстой асуудал. $p = 0.000 < 0.05$, тиймээс: Загвар статистикийн хувьд ач холбогдолтой байна Судалгааны үр дүнгээс үзэхэд байгууллагын ажилтнуудын стрессийн гол нөлөөлөгч нь дундаж утгаас үзэхэд хэт их хариуцлага, шийдвэр гаргах дарамт-1.52, ажлын ачаалал-2.02 болох тогтоогдсон. Иймд менежментийн түвшинд ажлын зохион байгуулалт, ажлын цагийн уян хатан болгох, хяналт, эрх мэдлийн тэнцвэртэй хуваарилалтад анхаарах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Байгууллагын стресс, ажлын ачаалал, харилцаа, ажлын сэтгэл ханамж
Удирдсан: Т.Норовсүрэн, МУБИС